

ЭРДЭНЭ БАНДИДА ХУТАГТЫН САН ЖАСЫН ТҮҮХЭЭС

Г. Баярмаа

Товч утга: XVII-XX зууны эхэн үеийн Монголын сүм хийдийн аж ахуйн зохион байгуулалт нь сан жас билээ. Сан нь хутагтын хувийн аж ахуй бол, жас нь дацан сүм хийдүүдийн аж ахуй санхүүгийн асуудлыг эрхлэн шийдэг байв. Хутагтын шавийн, сан, жасуудын эдийн засгийн хүчин чадал Монголчуудын үндсэн баялаг болсон малын тоо толгойн осолт, малын ашиг шим орлогоос хамаарч байсан. Энэхүү өгүүлэлд Халхын 13 тамгатай хутагтын нэг Эрдэнэ бандида хутагтын сан, жасуудын үйл ажиллагаа, аж ахуйн зохион байгуулалтыг МУҮТА-т хадаглагдан буй Эрдэнэ бандида хутагтын шавийн дансуудыг ашиглан тодруулахыг хичээв.

Түлхүүр үг: Эрдэнэ бандида хутагт, сүм хийд дацан, сан, жас

Оршил

XVII зууны сүүл үеэс Монгол оронд бурхны шашин хүчтэйгээр дэлгэрч, хутагт хувилгаад төрөн, сүм хийдүүд олноор байгуулагдсанаар нийгмийн бүтэц, эдийн засагт зарим өөрчлөлт гарсны нэг нь сүм хийдийн аж ахуйн зохион байгуулалтын хэлбэр болох сан, жас бий болсон асуудал юм. Энэхүү олноор байгуулагдсан сан жасууд нь Монгол орны эдийн засаг материал баялагын үйлдвэрлэлд хэрхэн оролцож байсаныг тодруулах нь чухал юм. Үүнийг Халхын арван гурван тамгатай хутагтын нэг Эрдэнэ бандида хутагтын шавиар жишээ болгон үзье.

Эрдэнэ бандида хутагтын судалгааг анх Ц.Насанбалжир 1969 онд “Эрдэнэ бандида хутагтын шавь”, Г.Батнасан “Ламын гэгээний сангийн ба жасын сүрэг хариулагчдын нүүдлийн тухай товч тэмдэглэл” өгүүллээр эхлэсэн юм. Ш.Нацагдорж¹, С.Пүрэвжав², Ц.Содномдагва³,

1. Нацагдорж Ш., Халхын түүх, УБ., 1963, Сүм хамжилга шавь ард, УБ., 1972, Монголын феодализмийн үндсэн замнал, УБ., 1978.

2. Пүрэвжав С., Монгол дахь шарын шашны хураангуй түүх, УБ., 1978, БНМАУ-д сүм хийд лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь, УБ., 1965.

3. Содномдагва Ц., Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалт өөрчлөлт, УБ., 1997.

М.Санждорж⁴, Ж.Болдбаатар⁵, Ө.Чимэд⁶, Б.Лааган⁷, А.Минис⁸, О.Пүрэв⁹ нар хутагтын шавь нарын тухай асуудлуудыг судлахдаа өөр өөрийн судалгааны бүтээлд дашрамын судалгаа хийсэн байдаг. Мөн анхдугаар дүр Лувсанданзанжанцангийн намтар, шашин, зурхай, ангаах ухааны судалгааг эрдэмтэн Д. Дашбадрах¹⁰, Л.Хүрэлбаатар¹¹, Ш.Сонинбаяр¹², Л.Тэрбиш¹³ нар хийж хэд хэдэн өгүүлэл хэвлүүжээ. Анхдугаар дүр Лувсанданзанжанцангийн мэндлэсний 360 болон 370 жилийн ойд зориулж судлаач Ж. Саруулбуян Ламын гэгээний цадиг оршивой, С. Юндэнбат Ламын гэгээний шавийн түүх номуудаа Эрдэнэ бандида хутагтын шавийн түүхийг нутгийн хуучжуудын аман дурдатгал дурсамж ашиглан бичсэн нь бий. Дээрх судалгаанууд нь хутагтуудын намтар, шашны талаас нь эс бөгөөс шавийн ард түмний амьдралыг Марксист түүх бичлэгийг баримтлан хутагт хувилгаадын шавь ардуудаас авах алба татварыг гол болгон мөлжлөг дарлал хэмээн тухайн үеийн үзэл сурталд тохируулан бичсэн байдаг.

Тиймээс энэхүү өгүүлэлд хутагтын аж ахуйн үйл ажиллагааг МУУТА-ийн Эрдэнэ бандида хутагтын шавийн дансуудыг ашиглан Эрдэнэ бандида хутагтын сан, жасууд бий болсон түүх, сүм хийдийн эдийн засгийн үндсэн баялаг болсон малыг сан дацангууд хэрхэн эзэмшиж шавь болох малчидаар маллууж байсан, шавь сүм хийдийн харилцааг тодруулах болно. Ийнхүү судалснаар тухайн үеийн Монголын нийгмийн нэг хэсэг болсон сүм хийдүүд тэдгээрт захирагдах шавь ардууд нь эдийн засгийн амьдралд хэрхэн оролцож байсныг тодруулан харах боломжтой болно.

1. Сан, жас бий болсон нь

Эрдэнэ бандида хутагтыг анх хувилгаанд тодруулсан тэр л үеэс ихэс ноёд сүсэгтэн олноос мандал даншиг, эд хогшил, мал сүрэг зэргийг ихээр өргөснөөр хутагтын сан анх үүссэн. Зая бандида Лувсанпэрэнлэй нь Лувсанданзанжанцангийн намтарт, "...Бар жил (1662) хар, шар, дээд, доод олон бээр угтаж, эл шарын хүндэтгэлийн дэлгэр жагсаалыг зохиожээ.

4. Санждорж М., Монгол шарын шашин дэлгэрсэн ба түүний харгис ролийн тухай асуудалд, УБ.,1959.
5. БолдбаатарЖ., Монголын бурханы шашны лам хувраг, УБ.,2010, т.124-136.
6. Чимид Ө., Их хүрээ сүм хийдийн мөнгө хүүллийн тухай, УБ.,1958.
7. Лааган Б., Сайн ноён хан аймгийн түүхэн хураангуй, УБ.,1999.
8. Минис А., МАХН-аас сүм хийд, сүм хийд лам нарын эдийн засгийн хүчин чадлыг эвдэж устгахын төлөө явуулсан тэмцэл, УБ.,1972.
9. Пүрэв О., Монголын түүхэн газар зүй, УБ.,2004.
10. Хүрэлбаатар Л., Огторгуйн цагаан гарьд II-боть, УБ.,2002, т. 89-110.
11. Дашбадрах Д., Монголын хутагтууд /XVII-XX зуун/, УБ.,2004, т.90-100, Монгол Төвдийн улс төр шашны харилцааны түүх, УБ.,1999, т.65-69.
12. Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704), УБ., 1999.
13. Тэрбиш Л., Ламын гэгээн Лувсанданзанжанцан түүний зурхайн бүтээл туурвил, УБ.,2004, т.133-171.

Хорин хоногийн турш зүг зүгээс их, бага, лам, ноён тэргүүтэн мөргөгч нар хийгээд маш сайн баяр хуримыг өргөгч нар ч сэтгэшгүй олон гарсаг нугуудыг ном хийгээд эд эдлээр ханган зохиож, Богд ламтан гэгээн хийгээд хан ба их, бага ноёд бүгдээр зарлиг зөвшөлцөөн хийж хайр хишгийг өгөн зохиов”¹⁴ хэмээжээ. Санг Гэгээн сан гэж нэрлэдэг. Сан нь хутагтын санхүү аж ахуйн байгууллага болон ажиллаж байв. Их санг Арвин буюу дотоод, Бадрах буюу гадаад гэж хуваадаг. Тус тусын ажил эрхлэх албан хаагчидтай.

Тухайлбал, Эрдэнэ бандида хутагтад бараа бологчид, үүнд дэргэд бараа бологч сойвон лам 2, донир 4, сэмбэн 2, гүндэмбэ 4, байсан ба эдгээр лам нар зоог, хувцас бэлтгэх, бурхан судар хадгалах, лавиран орд хариуцаж байжээ. Мөн сангийн ажил хийгчид соёг (аягач) 8, хаалгач лам 12, ордны див омбо (нярав) 4, Бадрах сан, Арвин сангийн нярав 4, сүрэг хариулсан нярав 1, түлээ хөрөөдөх хагалах, хог арилгах зэргээр няравын ажилд туслалцаж санд хар бор ажил хийдэг банди 24 байжээ. Лавиран ордны ба сангийн үйлчин, модчин, дархчууд гэж байжээ¹⁵. Эдгээр хүмүүс нь дотоод, гадаад сангийн ажил эрхлэдэг.

Хутагтын Арвин буюу (дотоод) сан Гэгээний зоог шүүсийг бэлтгэх, хувцас хэрэглэл, бурхан тахилын хэрэгслийг хадгалах, нарын нандин эд хогшил (торго дурдан, үнэт эдлэл) хэрэглэх хадгалах, өргөл барьцыг хүлээн авах гэх мэт ажил эрхэлдэг байв. Бадрах (Гадаад) сан мал сүрэг хариулах, өсгөх, бүртгэх, ашиг шимийг санд хураах, жин тээх, сүм дуган барих, засах, түлээ түлш бэлтгэх, худалдаа арилжаа хийх, тариа тарих, алба татах гэх мэт ажлуудыг хийдэг эдгээр сангууд нь хутагтын хувийн аж ахуй болон ажиллаж байжээ.

Харин анхны дүр Лувсанданзанжанцан Сайн ноёны хошууны Бөөрөлжүүт хэмээх газраа 1681 онд Гандандашгэмпэллин хийдийг гурван дацантай үүсгэснээр Эрдэнэ бандида хутагтын шавийн эх суурь тавигдаж мөн хийд орон, дацангуудыг даган анхны жасууд үүссэн бололтой. Манжийн хаанаас

Зарилгаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичигт заасанчлан, “Хэрэв шавь нар таван зуун хүнээс өнгөрсөн бөгөөд сүм харьяат хошуунаас бөглүү болсон нь таван зуунын газрын дотор болвоос, тамга тэмдгийг хамтаар олгуулж хураамжлан олгуулагтун”¹⁶ хэмээх заалтын дагуу хоёрдугаар дүр Лувсанванчинбалбарын үед, Тэнгэрийн тэтгэсний 2-р он (1737) улаагчин могой жил Их журганд уламжлан айлтгасанд, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас Халхын Эрдэнэ бандида хутагт, Зая бандида хутагт нарын шавь нар маш үлэмж, элдэв алба, зарлага, цэрэг гаргахад цөм сумын хүний хамт нэгэн адил явсан тулд өөр өөрийн

14. Мөн дээрх, т.147.

15. Насанбалжир Ц., “Эрдэнэ бандида хутагтын шавь,” Түүхийн судлал, Т-8, F-11, УБ., 1969, т.187.

16. Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдалын яамны хууль зүйлийн бичиг, Жардугаар дэвтэр, Лам нарын хуулийн тавдугаар 1488 зүйл.

шавь нарыг захирах тамга өгсүгэй хэмээн хэлэлцэж явуулжээ¹⁷. Мөн он буюу улаагчин могой жилийн намар цаг Эрдэнэ бандида хутагт хэмээх цолоор мөн шавь нарыг бүгдээр захирах тамга хэмээх Манж, Монгол, Тангуд гурван зүйлийн үсгээр сийлж цутгуулсан мөнгөн тамга олгуулжээ¹⁸.

Чингээд шавь нарыг захирах Шанзодубын тушаалыг гарган уул шавийг Сайн ноёны хошуунаас тусгаарлан бусад засаг ноёдын адил эрх бүхий болгож Сайн ноён аймагт харьяалуулан Цэцэрлэгийн чуулган даргад захируулах болсноор Эрдэнэ бандида хутагтын шавь албан ёсоор бий болжээ. Хоёрдугаар дүр Лувсанванчинбалбарын тухайд, “Тэрээр Баянзүрх уулын өвөрт Тэнгэр тэтгэсний 10-р он (1745) хөхөгчин үхэр жил 41 настайдаа Хангайн Баян-Өргөө (Баянзүрх) хэмээх уулын өвөрт Дэдлин хийдийг байгуулж. Мөн 47 онд шар нохой жил 74 насандаа Чогчин, Лавиранчиму, Нүвлэн, Шарлин, Гүшиг, Диваажин, Мамба, Чойр эдгээр том найман дацан дуганг байгуулсан”¹⁹ гэж буй. Ийнхүү Халх даяар нэрээ дуурсгасан Ламын гэгээний хүрээг байгуулсан ба тэдгээр сүм дуган, дацан хурал, лам нарыг дагалдан жас үүсчээ. Жасууд нь дацан сүм хийдүүдийн аж ахуйн асуудлыг эрхлэсэн шийдэг байв.

Дацангуудыг зайсан даргалах ба Шанзодубд шууд захирагдана. Зайсангийн удаах тушаалтан нярав бүлгээ. Нярав түүнтэй дүйцэх тушаалтан болох див, омбо нар нь сан, жасын данс харааг хөтөлж, гэрээ хийх, өглөг, хүлээн авах ажил үүрэг гүйцэтгэдэг жасын сан хөмрөгийг арвижуулах үүрэг бүхий чухал албан тушаалтнууд²⁰ ажилладаг байжээ. Дацан бүр өөрийн хурал номын үйл ажиллагааны зардалыг хариуцахын хамт дацангууд нь засаг захиргааны зохион байгуулалтын үүргийг давхар гүйцэтгэж байв. Шавь нар дацангуудад харьяалагдах бөгөөд Нүвлин хэмээх баруун дацангийн харьяат нар нь Шаргалжуут, Түйн гол, Орог нуурын хөвөө, Их богд уулын өврөөр, Диваажин, Мамба дацангийн харьяат нар мөн Их Богд уулын өвөр, Лэгийн гол, Орог нуур хавиар бусад дацангийнхантай хольцолдон нутагладаг байсан байна²¹.

Дацангуудын өрх, ам нь харилцан адилгүй байв. Олноо өргөгдсөн 12 (1922) оны нэгэн дансанд Нүвлин дацангийн харьяа 986 өрх, Шарлин дацанд 154, Гүншиг дацанд 330, Мамба 168, Жидарт 48, Диваажин 330 нийт 1813 өрх тоологдсон ба эдгээр малчин өрх нь хутагтын сан болон жасуудын маллыг малладаг байжээ. Тухайлбал, хутагтын сангийн малыг Нүвлин дацангийн 77 өрх бог, бод нийлсэн 7091 мал, Диваажин дацан 25 өрх 2375 мал, Шарлин дацангаас 19 өрх 1644, Мамба дацан 15 өрх 1285,

17. Насанбалжир Ц., “Эрдэнэ бандида хутагтын шавь,” Түүхийн судлал Т-8 F-11, УБ., 1969, т.183.

18. УНС, Гар бичмэлийн фонд, Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагтын сүм хийдийн уг эх, 3а.

19. УНС, Гар бичмэлийн фонд, Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагтын сүм хийдийн уг эх 4а тал

20. Юндэнбат С., Ламын гэгээний шавийн түүх, УБ., 2009, т.152.

21. Пүрэв О., Монголын түүхэн газар зүй, УБ., 2004, т. 37.

Жидар дацангаас 8 өрх 837 мал маллаж байжээ²². Сан жасууд нь сүм хийдэд хуримтлагдсан баялагийг нийгэмд хувиарлаж, эдийн засгийн эргэлтэнд хэрхэн оруулдаг байсныг дор өгүүлье.

2. Гадаад сан, жасуудын мал аж ахуй

Эрдэнэ бандида хутагтын шавийн сан жасуудын эдийн засгийн хүчин чадал нь малын тоо толгойн өсөлт, малын ашиг шим орлогоос хамаарч байв. Эрдэнэ бандида хутагтын шавийн ардуудын болон хутагтын сан, жасуудын мал сүрэг Живзундамба хутагтын Их шавийн дараа ордог байсан. Энд 1918 оны хүн ам, өрх, малын тоо бүртгэлийг Халхын тамгатай арван гурван хутагтын шавийн хүн ам, өрх, малын тоотой харьцуулж үзэв.

Хүснэг 1. Халхын 13 тамгатай хутагтын нарын хүн ам өрх малын тоо²³

Хутагт	Хүн ам	Өрх	Адуу	Тэмээ	Үхэр	Хонь, ямаа	Нийт
Сайн ноён хан аймаг							
Эрдэнэ бандида хутагт	8722	1997	10870	8516	12459	135504	167349
Зая бандида хутагт	8486	1723	17239	87	14653	38345	70324
Чин сүжигт номун хан	1666	272	206	340	3708	18935	23189
Нарванчин хутагт	658	130	1841	409	396	10895	13541
Эрдэнэ ноён мэргэн хутагт	560	124	531	339	489	6804	8163
Ширваа ширээт хутагт	1024	286	1207	1	2633	6989	10830
Наран хутагт	514	88	794	96	744	5472	7106
Хамба номун хутагт	1006	249	2163	37	3629	11900	17729
Цэцэн хан аймаг							
Ялгасан хутагт	2167	470	282	379	2033	8600	11294
Егүзэр хутагт	1107	301	645	75	1294	4074	6088
Засагт хан аймаг							
Жалханз хутагт	2003	545	2074	255	3166	7831	13326
Ялгасан хутагт	1387	262	2702	122	4722	13997	21543
Номун хутагт	771	175	720	341	1705	15754	18520

22. МУУТА, Х-137, Д-1, ХН-15.

23. Майский И., Современная Монголия, Иркутск.1921, стр.6-7.

Дээрх хүснэгтээс үзвэл, Эрдэнэ бандида хутагтын шавь нь Халхын арван гурван тамгатай хутагт нараас хамгийн олон өрх, хүн амтай, хамгийн их тэмээ, хонь, ямаатай харин адуу үхрийн хувьд Зая бандида хутагтын дараа хоёрдугаарт орж байна. Тийнхүү нийт малын тоо толгойгоор толгой цохих Эрдэнэ бандида хутагтын шавь нь Манжын хаанаас шавь захирах тамга авсан анхны тамгатай хутагтын нэг бөгөөд бусад тамгатай хутагтай харьцуулахад хамгийн том газар нутаг эзэмшидэг түүнийгээ дагаад олон шавийг захирдаг байв. Тус шавийн газар нутаг нь, хойд хилээс өмнөд хил хүртэл Тагын ойт хээрийн, хээрийн, говийн, ойт хээрийн, говь цөлийн (давхардсан байдлаар) долоон бүс физик газар зүйн (Хангайн, Хэнтийн, Говийн, Алтайн уулт) гурван мужийг дамнасан, хөрс ургамлын хамгийн олон төрөл бүхий байгалийн сайхан бэлчээр, тариалангийн талбайтай байсан²⁴ тул байгаль газар зүйн онцлог малын бэлчээр өвс ургамал нь таван зүйлийн малыг тэгш өсгөх таатай нөхцөл бүрдсэн байжээ. Ялангуяа тэмээн сүрэг өсгөхөд тун тохиромжтой нутаг байжээ. Эрдэнэ бандида хутагтын шавь нь нутгийн унаган сүрэг улаан хүрэн тэмээ, хээр алаг зүсмийн адуугаараа Халх даяар алдартай байсан гэдэг. Хутагтын сангийн тэмээн сүрэг түм хүрч тэмээн сүргийн манлай болох цагаан буурыг алтан товхтой мөнгөн буйлаар буйлалж байсан гэсэн нутгийнханы хууч яриа ч буй. 1918 оны тоогоор Эрдэнэ бандида хутагтын тэмээ Халхын хэмжээнд дөрөвдүгээрт орж байсныг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2. Аймаг хошуудын тэмээний тоо²⁵

Аймаг	Хошуу, шавь	Тэмээний тоо
Түшээт хан	Түшээт ван	28804
Сайн ноён хан	Үйзэн ван	19933
Түшээт хан	Дайчин бэйл	11518
Сайн ноён хан	Эрдэнэ бандида хутагт	8516
Цэцэн хан	Цэцэн ван	5558

Мөн хутагтын сан дацангуудын аж ахуйгаа хөтлөх нарийн дэг журам, сүм хийдүүд ажилч малч дундаж аж ахуйтнаар мал сүргээ маллуулж байсан зэрэг нь мал сүрэг өсөх ашиг орлоготой байхын үндэс нь болж байсан болов уу.

Хутагтын гадаад сан, жасууд олон малыг өмчлөж шавийн ардууд хариуцан малладаг байв. Эрдэнэ бандида хутагтын шавьд жил бүрийн тогтсон цагт малын тоо бүртгэл явагддаг байсан ч тухай нь тоо бүртгэлүүдээс үлдсэн нь 1838, 1882 оны данс төдий болно. Эдгээр данс буюу Хутагтын сан хэдий хэмжээний малыг эзэмшиж байсан, малчин өрхийн тоо, мал сүргийн бүтэц, өсөлт хорогдолыг хүснэгтээр илэрхийлбэл дараах мэт.

24. Пүрэв О, Монголын түүхэн газар зүй, УБ., 2004, т.36.

25. Майский И, Современная Монголия, Иркутск.1921.

Хүснэг 3. Төр Гэрэлтийн 18 (1838) он шороон нохой жил
Лавираннарчингийн сүрэг малын цоохор данс²⁶

Адуу			Хонь		Тэмээ		Монгол үхэр	Сарлаг үхэр	Нийт
Өрх	56	5	259	11	58	3	2	30	424
	Их сүрэг	Шинэ сүрэг	Их сүрэг	Дархан сүрэг	Их сүрэг	Шинэ сүрэг	Их сүрэг	Их сүрэг	
Хуучин	13037	1093	53696	3555	11888	499	156	2330	86254
Шинэ	12309	1051	59914	3976	10985	480	127	2463	91305
Дутсан	728	43			903	19	29		
Нэмсэн			6219	421				133	5051

Хүснэг 4. 1882 оны лавираннарчингийн сүрэг малын цоохор данс²⁷

Адуу			Хонь			Тэмээ		Монгол үхэр	Сарлаг үхэр	Нийт
	Их сүрэг	Шинэ сүрэг	Их сүрэг	Шинэ сүрэг	Дархан сүрэг	Их сүрэг	Шинэ сүрэг	Их сүрэг	Их сүрэг	
Өрх	36	4	104	10	8	45	3	3	8	221
Хуучин	7129	960	35991	4475	2325	8988	483	94	441	60886
Шинэ	7743	1012	38515	4730	2568	9013	490	97	573	64741
Дутсан										
Нэмсэн	614	52	2524	255	243	25	7	3	132	3855

26. МУУТА. ХМ-76, Д-1, ХН-8.

27. МУУТА. ХМ-76, Д-1, ХН-31.

Дээрх хоёр хүснэгтээс үзвэл, 1838 онд 424 өрх 91305 толгой мал тоолуулсан нь өмнөх жилээс 5051 малаар өссөн авч адуу, тэмээ сүрэг хэдэн зуугаараа хорогдсон байна.

1882 оны тоогоор хутагтын сангийн малыг 221 өрх 64741 тоо толгой мал хариулж, өмнөх 1881 оны 60886 малаас 3855 толгойгоор бүх төрөлд өссөн авч 1838 онтой харьцуулахад 26564 толгой малаар хорогдож, мөн малчин өрхийн тоо ч цөөрчээ. Энэ мэт мал хорогдсон шалтгааны тухайд, Эрдэнэ бандида хутагтын шавьд Бүрэн засагчийн 9 (1870) он буюу цагаан морин жил Баруун зуугаас гэнэт хулгай нар ирж, харьяа хүрээ сүмийн газар халдан харьяат хутагтын орныг түйвээсэн²⁸ гэх мэтээр хуйхуй цагаан малгайтны хоёр удаагийн дайралтанд хүрээ шавь ихэд өртөв гэсэн мэдээ байдагтай холбоотой буй за. Түүний зэрэгцээ давтамжтайгаар тохиолдог ган, зуд, өвчин тахал мөн мал хорогдох, малчид ядуурах шалтгаан болдог билээ. Гэвч Халхын Сэцэн хан аймгийн То ван буюу Тогтохтөр ган зудны улмаас ядуурсан хошууныхаа эдийн засгийг сайжруулахын тулд аж төрөх сургаал тархааж байсан шиг Эрдэнэ бандида хутагтын V дүр Лувсанданзанпэрэнлэйтогмид (1862-1907) шавийнхаа газар нутаг, цаг улирлын онцлогт тохирсон мал маллагааны арга журам нэвтрүүлэн хэрэгжүүлж байсныг Г.Батнасан²⁹, Ж. Саруулбуян³⁰, С. Юндэнбат³¹ нар дурьдсан байна.

Дээрх олон мал сүргийг хутагтын сангийн албан тушаалтнууд болох сангийн нярав, тамгийн зайсан нар жил бүрийн зуны сүүл, намрын эхэн сард сүрэг малыг нас хүйсээр нь ялгаварлан тоолдог байсныг жишээ хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5³². Малын нас, хүйс

Адуучин		Хоньчин		Тэмээчин		Үхэрчин	
Хиа Буд		Хув Дугар		Бат		Минжүүр	
Азарга	10	Хуц	13	Буур	2	Бух	2
Морь	80	Их	40	Ат	44	Шар	32
Гүү	118	Бага ирэг	56	Ингэ	128	Үнээ	23
Үрээ	9	Их	202	Тайлга	8	Гун	5
Байдас	10	Бага	41	Гунж	12	Гунж	2
Даага	13	Эм хонь	64	Тором	14	Бяруу	-
Унага	42	Хурга	61	Ботго	42	Тугал	10
Бүгд	285		548		253		74

28. МУУТА. ХА-73, Д-1, ХН-20.

29. Батнасан Г., "Ламын гэгээний сангийн ба жасын сүрэг хариулагчдын нүүдлийн тухай товч тэмдэглэл," Этнографийн судлал, УБ., 1969, т.31-35.

30. Саруулбуян Ж., Ламын гэгээний цадиг оршивой, УБ., 1999.

31. Юндэнбат С., Ламын гэгээний шавийн түүх, УБ., 2009.

32. МУУТА. ХМ-76 Д-1 ХН-31.

Мөн тамга тэмдэг хийх, сүргийн шинэ суурь байгуулах (их сүрэг, шинэ сүрэг, дархан сүрэг, үржил сүрэг) бусдад шилжүүлэн хариулгах, дутсан малын төлүүлэх, зэргээр нарийн бүртгэл байцаалтыг хийн дансалдаг байв. Жишээ нь: Дарга Хөх гаднаас хэрэгт 10 морь, гүү 5, нийт 15. Алдсан -, хулгай -, чоно -, үхсэн Азрага 1, морь 4, гүү 8, даага 8, унага 28 нийт 48. Хуучин 322, шинэ 294, дутсан 28, барьсан сүүл 48 хөгшин азарга 1, гүү 4-ийг 1 даага 4 унагаар өгөв. 14 онд алдсан морь 3-ыг хэвээр төлүүлэв³³ гэх мэтээр байцаалга данс үйлдэж байв. Энэ мэтээр мал хариулагч өрхүүд бүх төрлийн малд данс тэмдэглүүлж алдсан, хувьдаа ашигласан малыг төлүүлэх, үхсэн малын арьс шир сүүлийг тоо ёсоор нь тушаах, хөгширсөн малыг залуу малаар солих, малын төлбөрт бага насны мал авах гэх мэтээр сан, жасууд мал хариулгах журам нь уул сүргийг осол эндэгдэлгүй хариулж, тоо толгойг нэмэгдүүлэх үүргийг хүлээдэг байв. Мөн сүм хийдүүд хариуцлаг хүлээх, хорогдолын төлөх чадвар бүхий өрхүүдээр малаа маллуулж байсан. 1922 оны хүн ам, мал сүргийн бүртгэлд сан жасууд доод тал нь багадаа 30 (цөөн тохиолдолд) эрхэвчлэн 100-аас дээш малтай өрхүүдээр малаа маллуулж байсан нь харагддаг. Тухайлбал шавь Сономпил нас 28, өрх 1, эмс охид 3, адуу 100, тэмээ 30, үхэр 101, хонь, ямаа 411 гээд Нүвлин дацангийн ард сангийн 85 адуу, 91 тэмээг давхар хариулж байсан.³⁴ Сүрэг хариулагчид дунджаар нэг өрхөд малын нэг төрлөөс 80-120 орчим малыг маллуулдаг байжээ. Жишээ нь Нүвлэн дацанд Тэмээ 1293-ийг 16 өрх, адуу 1137-ийг 13 өрх, үхэр 203-ийг 5 өрх, хонь 4458-ийг 43 өрх тус тус хуваан маллаж байжээ.

Сүрэгчид хариулж байгаа малынхаа ноос, үс, сүү цагаан идээнээс зохих хувийг алба болгон сан жасуудад тушаадаг үлдсэнийг нь ахуй амьдралдаа ашигладаг байв.

XVIII-XIX зууны үеийн Эрдэнэ бандида хутагтын шавийн сан жасуудын малын тоо бүртгэлийг нарийвчлан тодорхойлох данс одоогоор олж үзсэнгүй. Харин XX зууны эхэн үеийн зарим нэг сан, жасуудын данс бүртгэлийн мэдээ Үндэсний төв архивийн газарт хадгалагдан байна. Тэдгээр данс бүртгэлээс 1916-1928 оны Бадрах сангийн данснаас (Хавсралт хүснэг) үзэхэд, Бадрах сан нь 20 орчим өрхөөр бог, бод нийлсэн жишээ нь 1916 оны байдлаар 1773 мал маллуулж байв. Үүнээс харахад тус сангийн мал сүргийн өсөлт 1923 оныг хүртэл харьцангуй тогтвортой, харин 1924-1928 онуудад малын төрөл тус бүр дээр мал хорогдсон байна. Дээр дурдсан данс мэт ард нь байцаалга үйлдээгүй учир малын хорогдолын шалтгаан тодорхойгүй. Мөн хутагтын гадаад санг Бадрах сан гэж ерөнхийд нь нэрлэгдэх хутагтын сангийн аж ахуйн бүх асуулдыг хариуцсан газар байсан билээ. Харин энд дурдагдах Бадрах сан нь хутагтын сангийн мал аж ахуйг хариуцсан газрын нэг хэсэг байсан бололтой. Учир нь хутагтын мэдлийн сангийн мал сүрэг нь 1000

33. МУУТА. ХМ-76 Д-1 ХН-8.

34. МУУТА. ХФ-137 Д-1 ХН-15.

гаруйхан байгаагүй юм. 1922 оны тоо бүртгэлээр Эрдэнэ бандида хутагтын сангийн малыг найман дацангийн олон өрхийн хариуцан малладаг хонь 7846, адуу 2216, тэмээ 2073, үхэр 304 нийт 12439 мал тоологдсон байдаг.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын ялалтаар төрийн бүх эрх ардын засагын гарт шилжсэнээр сүм хийдүүдийн талаар шат дараалсан олон арга хэмжээг авч эхлэв. Тухайлбал, хүн малын тоо бүртгэлийн ажил, засаг захиргааны өөрчилт, сүм хийдийн мал, эд хөрөнгөд татвар оногдуулах гэх мэт болно. Тэдгээр данс бүртгэлээс өмнө бүрхэг байсан жасын малын тоо хэмжээ, сан жасуудын нэр хаяг, малчин өрхийн тоо, малын өсөлт болон хорогдол гэх мэт олон зүйлийг мэдэж болохоор байна. Түүний дотор хамгийн их мэдээлийг өгч чадахуйц данс бол 1922 оны хүн амын тоо, мал сүргийн бүртгэл данс бөгөөд түүнээс хутагтын дацангуудийн сан, жасууд, мал сүргийг хүснэгтээр үзүүлсэн доорх мэт.

Хүснэг 6. Эрдэнэ бандида хутагтын 1922 оны сан жасын малын тоо³⁵

Сан, жас	Нүвлин	Чогчин	Чойр	Мамба	Гүшиг	Шарлин	Жидар	Диваажин	Арвин сан
Өрх	77	24	12	19	1	19	8	30	25
Адуу	1137	82	13	374	3	276	84	370	321
Тэмээ	1293	27	-	264	-	796	-	526	25
Үхэр	203	101	48	99	-	-	17	40	30
Хонь	4458	1292	331	580	-	575	736	1505	1013

Нийт: 16804 тоо толгой мал сан жасуудын мэдэлд байв.

Эрдэнэ бандида хутагтын сан жасын малын тоог төрөл тус бүрээр он дарааллаар харьцуулсан нь Хүснэг 7 болно.

35. МУУТА. ХФ-137 Д-1 ХН-15.

Хүснэг 7. Жасын малын тоо³⁶

Он	1918			1923	1924	1925	1926	1927
	сангийн	сүм хийдийн мэдлийн	нийт					
Адуу	1660	556	2216	2773	4884	3670	3515	3635
Тэмээ	3031	141	3172	2975	5279	5302	4905	9297
Үхэр	229	129	358	513	1774	1648	1700	470
Хонь	7549	1693	9242	10543	18070	19793	19633	24735
Ямаа				648 107				
Нийт	12469	2519	14988	16804	30007	30413	30437	38244

Эдгээр данс бүртгэлээс үзэхэд, ардын засгаас сүм хийдүүдийн эдийн засаг, эрх хэмжээг хязгаарлах олон арга хэмжээг авч байсан хэдий ч 1928 оныг хүртэл сан жасын үйл ажиллагаанд төдий л өөрчлөлт оролгүй хэвийн явагдаж, малын тоо толгой өсөж байжээ. Харин Намын төв хорооноос 1921 оны аравдугаар сард засгийн газраас явуулсан нэгэн бичигт сүм хийдийн мал хөрөнгөнөөс алба татвар хураах нь зүйтэй гэж үзээд жасын малд үнэ зохиож хувьд оруулан түүнээс 20% албан татвар авч байхаар зохих дүрэм хэмжээг боловсруулахаар зааж³⁷, сүм хийдийн мал, эд хөрөнгөд татвар оногдуулах болсоноор 1922 онд 8 жас байсан бол 1924, 1925 оны тоо бүртгэлд 27 болж олширсон нь сүм хийд дотооддоо өөрчлөлт хийсэний илрэл буюу алба татвараас зайлас хийх гэсэн оролдлого байв (Хавсралт хүснэг). 1926 онд хуралдсан Монгол ардын хувьсгал намын V их хурлаар сүм хийдийн мал хөрөнгөөс албан ёсоор албан татвар авах шийдвэр гарсан юм.

Сүм хийдийн аж ахуйн гол баялаг мал сүрэг нь сүсэг бишрэл өргөл барьцнаас үүссэн хэдий ч хутагтын сан, дацан, жасуудын өсөлт бэхжилт нь аж ахуйгаа хөтлөх зохион байгуулалт бүхий үйл ажиллагаатай салшгүй холбоотой байв. Сан жасууд мал сүргээ эдийн засгийн чадавх бүхий ажилч хичээнгүй малчин өрхийг сонгон маллуулж байв. Сонгогдсон малчин өрхүүд сүм хийдийн малыг хариулж өсгөх үүрэг хүлээхийн хамт малаас гарах ашиг шимийг хүртэх, сүм хийдийн бэлчээр нутгийг ашиглах эрх мэдэлтэй болдог. Малчид байгалийн гамшиг, ган зуд тохиолдсон үед шавийн хамгийн сайн өвс ус, хужиртай газар нутаг бэлчээрийг сонгон сүм хийдийн малын хамт өөрсдийн хувийн малыг хамт давхар маллаж өсгөн үржүүлж, ашиг шимийг хүртдэг байна.

36. 1918 он: Майский И, Современная Монголия, Иркутск. 1921, стр. 6-76, 1923 он: МУУТА. ХФ-137, Д-1, ХН-15. 1926 он: ХФ-137, Д-2 ХН-8-1, 1927 он: МУУТА, ХФ-137 Д-2 ХН-156. 1924, 1925 он: Насанбалжир Ц., "Эрдэнэ бандида хутагтын шавь" Түүхийн судлал Т-8 F-11, УБ., 1969, т.194-195.

37. Минис А, МАХН-аас сүм хийд, лам нарын эдийн засгийн хүчин чадлыг эвдэж устгахын төлөө явуулсан тэмцэл, УБ., 1972, т.69.

Сүм хийдийн мал сүргийг хариулах нь малчин ардуудад эдийн засгийн хувьд ашигтай байсан хэдий ч тэдний сүсэг бишрэл, итгэл үнэмшил тодорхой хэмжээнд нөлөөлж байсныг үгүйсгэж болохгүй.

Сүм хийдийн мал сүргийг хариуцлага хүлээх чадвартай ажилч малчин өрхийг сонгон маллуулдаг байсан нь нийгмийн дундаж аж ахуйтнуудад ашиг тустай, сүм хийд, малчин хоёрын харилцан ашигтай, үр дүнтэй хамтын ажиллагаа байжээ.

XVII-XX зууны 20-иод оныг дуустал хугацаанд дээрх хоёр талын хамтын үйл ажиллагаа нь нүүдлийн мал аж ахуй эрхлэдэг Монгол орны материал баялгийн үйлдвэрлэл, хуваарилалтад оролцож буй гол хэлбэр байв.

Abstract: In this paper it is aimed to clarify some details on the *jisa* properties of Erdene Bandida, one of the 13 Khalkha Khutagtus that have been entrusted the seals. The materials of his properties and their function and activities that were in the Central Archive of Mongolia gave me some clarification not only on the population of his shabi, the structure of his herd but also on the relations between monasteries and herders which were profitable for both parties.

Хавсралт. Хүснэгт

Бадрах сангийн сүрэг малын данс³⁸

Он	1916	1917	1918	1919	1920	1921	1922	1923	1924	1925	1926	1927	1928
Адуу													
Өрх	4	4	4	4	4	4	4	5	5	4	4	4	4
Хуучин	472	484	503	522	552	502	509	534	443	394	354	347	337
Шинэ	484	503	522	552	502	509	534	443	394	354	347	337	293
Дутсан	-	-	-	-	50	-	-	-	46	40	7	10	44
Нэмсэн	12	29	19	30	-	7	25	91	-	-	-	-	-
Хонь													
Өрх	10	10	10	11	11	11	11	11	11	10	10	7	7
Хуучин	699	700	675	745	766	722	743	733	642	663	621	559	511
Шинэ	700	675	745	766	722	743	733	642	663	621	559	511	351
Дутсан	-	25	-	-	-	-	10	91	-	42	62	48	160
Нэмсэн	1	-	70	21	44	21	-	-	21	-	-	-	-
Тэмээ													
Өрх	5	5	5	6	6	6	6	7	7	7	7	7	3
Хуучин	523	517	536	557	529	527	516	520	510	478	457	425	405
Шинэ	517	536	557	526	527	516	520	510	478	457	425	405	315
Дутсан	6	-	-	28	2	11	-	10	32	21	32	20	90
Нэмсэн	-	19	21	-	-	-	4	-	-	-	-	-	-
Монгол үхэр													
Өрх	1	1	1	1	1	-	-	-	-	-	-	-	-
Хуучин	12	14	13	13	12	-	-	-	-	-	-	-	-
Шинэ	14	13	13	12	7	-	-	-	-	-	-	-	-
Дутсан	-	-	-	1	5	-	-	-	-	-	-	-	-
Нэмсэн	2	1	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сарлаг үхэр													
Өрх	3	3	3	3	3	3	4	4	4	4	2	-	-
Хуучин	51	58	77	89	94	103	114	126	135	136	141	-	-
Шинэ	58	77	89	94	103	114	126	135	136	141	53	-	-
Дутсан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Нэмсэн	7	19	12	5	9	1	12	9	1	5	88	-	-

38. Уг хүснэгтийг хийхэд МУУТА. ХА-73 Д-1 ХН-7, 8, 9, 11, 14, ХФ-137 Д-1 ХН-11, 12, 14, Х-145 Д-1 ХН-2, ХФ-137 Д-1 ХН-202-3,4, 1923, 1926 оныг нөхөж гаргав.

Цэцэрлэг мандал аймгийн Баянзүрх уулын хошууны 1924 оны жасын малын тоо³⁹

Холы амьд	Үхэр	Адуу	Тэмээ	Жасын нэр	Өрх	
3065	263	1803	3763	Лаиран	106	1
727	139	397	551	Барах сангийн	25	2
928	76	365	66	Гэлэр	26	3
8437	201	726	429	Дүйнхор	92	4
1104	132	62	23	Санлуй жүд	10	5
478	85	72	17	Мөнх үш	13	6
876	103	52	28	чогчин	8	7
304	16	16	57	Моломын	7	8
673	44	59	21	Дорждарма	16	9
428	103	32	33	Нүвлин	6	10
647	146	19	42	Моломын дэв	17	11
162	85	1	19	Хүүдэр хурал	8	12
521	49	-	-	Хүрээний доряг	8	13
72	23	41	1	Шарлин	4	14
186	20	11	12	Мөн боломын хурал	7	15
-	8	5	-	Гүшиг	1	16
179	16	12	23	Мөн боломын	6	17
215	12	-	10	Мөн хүүдэр хурал	6	18
12	35	17	8	Диваажин	5	19
220	53	42	19	Мөн боломын	5	20
43	36	-	11	Мөн хүүдэр	3	21
128	7	90	32	Онжин	9	22
252	14	9	4	Мамба	6	23
936	38	33	31	Мөн боломын	8	24
456	36	13	38	Жий	12	25
65	23	-	-	Мөн боломын	2	26
187	21	25	24	Санжид	8	27

1925 оны жасын малын тоо⁴⁰

Холы амьд	Үхэр	Адуу	Тэмээ
3630	263	1779	3889
634	141	343	468
914	68	329	71
7718	236	699	533
377	53	49	17
355	114	72	13
774	88	54	15
314	16	-	55
585	47	55	24
313	99	47	39
740	93	19	46
150	53	-	19
526	38	-	-
59	27	42	1
173	32	20	7
-	11	9	-
120	9	19	13
199	11	-	13
15	21	24	7
343	14	44	13
44	19	-	12
134	9	89	32
7	10	6	2
932	37	19	29
307	37	6	43
274	23	-	-
164	42	21	20

39. МУУТА. ХФ-137 Д-2 ХН-3

40. МУУТА. ХФ-137 Д-1 ХН-95.